



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 863

Улаанбаатар хот

**Хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэрийн нийт 157,366,177.33 (нэг зуун тавин долоон сая гурван зуун жаран зургаан мянга нэг зуун далан долоон төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201738

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 1-р дугаар сарын 18-ны өдрийн  
183 дугаар тогтоолын хавсралт

**"ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Нийт гүйлт /км/	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Дуудлагаар худалдах доод үнэ
1	Ачааны автомашин камаз 5320, 48-56 УББ, 2067323	538487	1994	50,686,938.00	3,700,000.0	1,500,000.0
2	Фургон УАЗ 220692, 71-73 УБЯ, 37410020148727	444849	2002/2003	7,546,500.00	1,500,000.0	1,500,000.0
3	Фургон УАЗ 220692, 66-19 УБК, 30480891	414758	2003/2005	6,376,500.00	1,500,000.0	1,500,000.0
4	Ачааны автомашин бортовой Зил-130, 17-48 УБД, L3070685	91356	1990/2004	26,121,960.00	1,800,000.0	1,800,000.0
5	Фургон УАЗ 22069-033, 58-59 УБТ, 80467756	200507	2008	66,634,279.33	1,500,000.0	1,500,000.0
				<b>157,366,177.33</b>	<b>10,000,000.00</b>	<b>7,800,000.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>				(нэг зуун тавин долоон сая гурван зуун жаран зургаан мянга нэг зуун далан долоон төгрөг гучин гурван мөнгө)	(арван сая)	(долоон сая найман зуун мянган)